

“ИНЬ, ЯНЫ” ФИЛОСОФИЙН АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Р.Дарьхүү - МУИС-ийн философийн тэнхмийн эрхлэгч, тэргүүлэх профессор
П.Батхүү - Хөвсгөл аймгийн “Ирээдүй” сургуулийн багш, докторант

Түлхүүр үгс: “инь”, “ян”, “ци”, өөрчлөлт, “ба-гуа”, эв нэгдэл

Товч утга: Энэхүү өгүүлэлд “инь, яны сургаалын арга зүйн онцлогийг тайлбарлахыг зорилго болгов. “Инь-яны” сургаалын үндсэн агуулгыг уг үзлийн сонгодог бүтээл болох “И-зин”⁴ буюу “Өөрчлөлтийн сударт” тулгуурлан авч үзлээ. “Инь-яны сургаал” /Yin-Yang/ нь хятадын сонгодог философийн үндсэн чиглэлийн нэг юм. “Инь, яны” философийн арга зүй нь түгээмэл ач холбогдолтой. Энэ арга зүй нь бидний өдөр тутмын амьдралд төдийгүй шинжлэх ухааны танин мэдэхүйд ч арга зүй болж байгаа билээ. Иймд энэ арга зүйг орчин үеийн шинжлэх ухааны аль ч салбарт нарийн төвөгтэй тулгамдсан асуудлыг шийдэхэд хэрэглэх боломжтой. Энэ арга зүйн үндсэн баримтлал бол туйлшрах сэтгэлгээнээс ангижрах, үзэгдэл үйл явцын эсрэг тэсрэг болон зөрчилт олон талын харилцан хамаарал, өөрчлөлт, шилжимтгий харьцангуй байдлыг харгалзан үзэх явдал юм.

“Инь-яны философи” нь өөрчлөлтийн зарчмыг гол баримтлал болгодог юм. “Өөрчлөлтийн сударт” өгүүлснээр, “Инь, ян хэмээх эсрэг хүчнүүд, тэдгээрийн харилцан үйлчлэл бол ертөнцийн оршин буй бүхний үндэс, мөн бүхний хувьсал өөрчлөлтийн үндсэн шалтгаан болдог”⁵ ажээ. “Инь” хэмээх ойлголт нь газар, эх хүн, харанхуй, хүйтэн, зөөлөн, идэвхгүй (тайван байдлыг) эхлэлийг, өөрөөр хэлбэл, билгийн талыг илэрхийлдэг. Харин “ян” хэмээх ойлголт нь тэнгэр, эцэг хүн, гэрэл, халуун, хатуу, идэвхтэй (хөдөлгөөнийг) эхлэлийг, өөрөөр хэлбэл, аргын талыг илэрхийлдэг байна.

Цааш нь энэ бүтээлд бичсэнээр: “Тэнгэр гэж цаглашгүй өндөр билээ, газар гэж нам билээ, учир тиймийн тул тэнгэр ч газар ч тогтмол байнгын юм. Өндөр нам хоёр зохицон тодорхой орших тул шударга номхон хоёр тус тусын байрандаа буй нь тэр бөлгөө. Идэвх амгалан хоёр байнгын, хүчтэй сул дорой хоёр ялгаатай ажгуу. Арга зам аяндаа хамтдаа олдох ба элдэв юмс нь зэрэг дэвээ дагаад ангид оршино. Учир тиймийн тул сайн хийгээд муу заяат буй болно. Тэнгэрт, тэнгэрлэг бодгаль нь үзэгдэж, газар дээр амьд амьтас тохиолдоно. Өөрчлөлт хувиралт тэдэнд л үзэгдэнэ. Тийнхүү хүчтэй хийгээд сул дорой хоёр нь харилцан үйлчилж Найман хүлэл тэдгээрийг тус бүрд нь идэвхжүүлнэ. Аливаа юмс нь аянга цахилгаанд идэвхжин хөдөлж салхи бороогоор баяжна. Нар сар хоёр нь орчих замдаа орчин эргэлдэж халуун хүйтэн улирал тэр эргэлтэнд нь орно. Ch'ien (тэнгэр) нь эр эхлэлийг, K'un (газар) нь эм эхлэлийг төлөөлөн бэлгэднэ. Ch'ien (тэнгэр) нь Их эхлэлийг тавьж, K'un (газар) нь аливаа юмсыг төгс болгоно.

⁴ “И-зин” хэмээх зохиолын нэрийг “Хувьслын судар”, “Зурхайн ном” гэх мэт монгол хэлээр янз бүр хөрвүүлсэн байна.

⁵ A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P.244

Ch'ien (тэнгэр) нь амар хялбарыг чухалчлахад K'un (газар) нь аливаа энгийнйг эрмэлзэнэ”⁶.

Энэхүү эсрэг тэсрэг хоёр хүч нь харилцан биенийгээ үгүйсгэхийн хамт, бас нөхцөлдүүлж, эцсийн эцэст нэгдэл, зохицолд оршдог бөгөөд тэрхүү нэгдмэл байдлыг “Ци” /Chi/⁷ хэмээх ойлголт илэрхийлдэг. Хятад хэлэнд “Ци” хэмээх ханз үсгийн утга нь амьдрах хүч бөгөөд философи утга нь анхдагч материаллаг хэсэг гэсэн ойлголт юм. Эл натурфилософийн үзлээр, “Ци” буюу инь, яны харилцан үйлчлэлээс орчлонгийн бүх юмс үзэгдэл төрөн гардаг, бас хувиран өөрчлөгддөг. Эдгээрийн олон талт харилцан үйлчлэлийг “Өөрчлөлтийн сударт” гурвалсан зураасаар илэрхийлдэг.

Хүлэлийн тасархайгүй шулуун зураас бол ян (арга), тасархай зураас нь инь (билэг) юм. “И-зин” зохиолд “Ба-гуа” буюу найман хүлэлээр ертөнцийн зүг чиг, орон зай, цаг хугацаа зэрэг олон зүйлсийн харилцан холбоо хамаарлыг тайлбарласан байдаг. Үүнд: Цянь-тэнгэр /эцэг/, Кунь газар /эх/, Дуй-нуур, Ли-гал, Сунь-мод /охид/, Гэнь-уул, Кань-ус, Жэнь-аянга /хөвгүүд/ хэмээн найман хүлэлийг хүнчилж тайлбарласан буй. Эдгээрийн дотроос газар, уул, ус, аянга зэрэгт “инь” хүчин зонхилж байхад, харин тэнгэр,



нуур, гал, мод зэрэгт “ян” хүчин зонхилж байдаг. Цаашилбал, гурвалсан тасархайгүй шулуун зураас нь тэнгэр, эцэг хүн, зун, өмнө зүгийг тэмдэглэдэг бол гурвалсан тасархай зураас нь газар, эх хүн, өвөл, хойд зүгийг тэмдэглэдэг. Бусад хүлэл нь энэ хоёрын харилцан үйлчлэлээр үүсдэг. Мөн Цянь, Кунь хоёрыг эцэг, эх гээд бусад хүлэлийг хөвгүүд ба охид хэмээн хүнчилж нэрлэдэг. “Ли” буюу хоёр захдаа шулуун дундаа нэг тасархай гурвалсан зураас нь гал, намар, дунд охин, баруун зүгийг; үүний эсрэг Кань /ус/ бол хавар, дунд

хөвгүүн, зүүн зүгийг тус тус тэмдэглэдэг байна.

Эдгээр хүлэл нь анх гурвалсан зураасаас бүрдэж хүн, газар, тэнгэр гурвын харилцан үйлчлэлийг тэмдэглэдэг байжээ. Танин мэдэхүйн хөгжлийн явцад гурвалсан зураас бүхий эгнээ хоёр дахин их болсноор зургаан зураасаас бүрдэх болжээ. Түүнийг гексаграмм хэмээн нэрлэдэг. Найман хүлэлд 24 зураас тэмдгийн өөрчлөлт нь харьцангуй энгийн байдаг. Харин 64 хүлэлд 384 зураас болж илүү олон өөрчлөлтийг тодорхойлж, энэ өөрчлөлтүүд нь байгаль нийгэмд явагдаж байгаа ямар ч төвөгтэй харилцаа холбоо, хамаарлыг тайлбарлан харуулж чаддаг байна.

Тухайлбал, анхны гексаграмм нь Ch'ien (тэнгэр)⁸ юм. “Өөрчлөлтийн сударт” өгүүлэхдээ: “Аливаа бүхний эх тэнгэр агуу билээ! Аливаа бүхэн түүнээс үүсэлтэй билээ. Тэнгэр нь аливааг нэгтгэж захирна. Үүл нүүж бороо орно, аливаа зүйл хоорондоо учир уялдаатай билээ.

⁶ Мөн тэнд. Р.265

⁷ Oxford dictionary of philosophy. Shanhai. 2000. p.401

⁸ A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P.264

Ийнхүү эхлэл төгсгөлийг жам ёсоор нь ойлгоход энэ буюу, гексаграммын зургаан байрлал цаг үедээ оноогдох нь билээ. Ch'ien (тэнгэр) нь ямагт зургаан шугамын зургаан луу /ch'i буюу материаллаг хүч/ хөлөглөж тэнгэрийн доорх аливааг хянан захирна. Ch'ien (тэнгэр)-ийн зам нь гэвэл: аливааг өөрчлөн хувиргаж байгалийн жам ёсны хэлбэрт буюу Ming замд оруулах их зохирлыг бүтээх ажгуу. Ингэх аваас, цамхагийн оройд орших түм буман зүйлс хийгээд түмэн олон амирлан жаргах буй заа...

Агуу суут хүний тухай ухагдахуун нь Тэнгэр Газрынхтай ижил төстэй бөгөөд түүнээс ялгарах их гэрлийн туяа цацраг нь нар сар мэт лугаа хэмээв...түүний ач тус буян нь аливаа оюунлиг амьтаныхтай адил хэмээнэ. Тэнгэр Газрын өмнө явахаас биш Тэнгэр газартай тэрсэлдэн тэмцэхгүй, Тэнгэрийг дагахаас биш Тэнгэртэй сөргөлдөхгүй..."гэжээ.

Мөн дээрх бүтээлд хоёр дахь гексаграмм болох K'un (газар) – ын тухай өгүүлэхдээ: "Шулуун цэх явна гэдэг нь үнэн зөв явна гэсэн үг, хөндлөн харна гэдэг нь чигч үнэн явна гэсэн үг. Ахмад хүн нухацтай байх аваас дотоод сэтгэлээ цэгцэлнэ, цэгц шудрага байвал гадна сэтгэлээ засна. Нухацтай чигч үнэнч явах аваас хэн хүний буянт явдал бусдаас тусгаар ангид явахгүй. Цэгц шулуун шудрага их үйл бүтээх ахмад хүн аливаа үйлсдээ их хүчин чармайлт гаргахгүй бөгөөд аливаад ямагт урагштай явна"⁹ гэсэн буй. Энэхүү философийн "Нухацтай байх аваас дотоод сэтгэлээ цэгцэлнэ, цэгц шударга байвал гадна сэтгэлээ засна" гэсэн ёсзүйн томъёолол нь их чухал баримтлал бөгөөд хожим күнзийн шинэтгэсэн сургаалын үндэс болсон байдаг.

Ийнхүү Тэнгэр Газрын мөн чанар нь бүтээхүй үйлдэхүй билээ. Мэргэн ухааны хамгийн нарийн нандин зүйл бол дээд байр суурь билээ. Тэр байр сууриа хадгалах нь тухайн хүний ухаан мэдэх, хүмүүнлэг чанараас хамаарах хэрэг. Хүн хэр олон болох нь эд баялаг хэр арвин элбэг дэлбэг байхаас хамааран шалтгаална. Эд баялгийг зөв захирч зарцуулна гэдэг нь бололцоо нөхцлийг хязгаарлана гэсэн үг. Зөвөөр захиран зарцуулж бололцоо нөхцлийг хязгаарлаж хүмүүнийг буруу зүйлээс сэргийлэх аваас шудрага ёс тэр болой.

Эртний Хятадад гексаграммаар мэрэг хийхэд "гексаграмм нь тэмдэг, тоо, тайлбар гэсэн гурван үндсэн хэсгээс бүрддэг"¹⁰ бөгөөд эдгээрийн дүгнэлтээр азтай ба азгүй явдал, жаргал ба зовлон гэх мэтийг тааварладаг байжээ. Үүнд:

- Тэмдэг нь гексаграммын зураг ба хар цагааныг илэрхийлсэн зураасуудын нийлбэр юм.
- Тайлбар нь гексаграммын бүх зураасыг тайлбарлана.
- Тоо нь хэмжээг илэрхийлдэг ажээ.

Инь, яны сургаалд өгүүлснээр¹¹, "Ян нь үргэлж сондгой тоог (тэнгэрийн тоог), Инь нь үргэлж тэгш тоог (газрыг тоог) илэрхийлдэг. Энд тайлбарласнаар, "1, 3, 5, 7, 9 тоо нь тэнгэрийн тоо, 2, 4, 6, 8, 10 тоо нь газрын тоо болно.

⁹ A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P.264

¹⁰ Р.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006

¹¹ Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 129-130 дахь тал

Газрын тоо, тэнгэрийн тоо нь хоорондоо зохицож, бие биенээ нөхөн гүйцээж байдаг. Түүнчлэн 1 гэсэн тэнгэрийн тоо нь усыг үүсгэж, зургаа гэсэн газрын тоо нь түүнийг устгадаг. 2 хэмээх газрын тоо нь галыг үүсгээд долоо гэсэн тэнгэрийн тоо нь түүнийг устгадаг гэх мэтчилэн: 1, 2, 3, 4, 5 гэсэн тоонууд 5 элементийг үүсгэж, 6, 7, 8, 9, 10 гэсэн тоонууд нь тэднийг устгадаг байна”.

Энэ бүхнээс үзэхэд энэ үзэл нь рационал хандлагатай ба улмаар ертөнцийн бүтцийн тухайд гэвэл тун ч эмх цэгцтэйгээр, өөрчлөлт хувиралтад нь авч үзжээ. Энэхүү сургаалын орчлон ертөнц тэр болгон цэгцтэй дэгтэй зүйл биш, түүн доторх хүмүүн хийгээд байгаль дэлхий эв нэгдэл, нэгэн бүтэн цогцын хэлбэртэй гэдэг үзэл санаа нь чухал байгаа болно. Энэхүү идэвхтэй үйл ажиллагаа нь орчлын буюу эргэлт давтамжийн хэлбэртэй байх ба арга билигийн харилцан шүтэлцээ, барилдлага нь урагш тэмүүлэх хөдөлгөөнтэй байж, нийгэм, ёс суртахуун болон хүмүүн төрөлхтөний соёл иргэншлийг урагшлуулж байдаг хөдөлгүүр нь юм.

Мөн энэ үйл явц нь Анхдагч эхлэлээс (T'ai-chi) үүсэлтэй ажээ. Арга билиг нь үүнээс үүсэх ба тэдгээр нь их бага арга билигт хамаарах дөрвөн хэлбэр болно. Хэлбэр гэсэн ухагдахууныг томъёолсон hsiang ханзаар нь бэлгэдэл, үлгэр жишээ буюу загвар, үзэл санаа гэсэн утгыг тэмдэглэнэ. Энэ нь, сансрын хоёр их хүчнээс ангид, аливаа бэлгэдэл, үлгэр жишээ буюу загвар, үзэл санаа, тогтолцоо нь хөгжиж хувьсаж байдаг гэсэн үг юм.

Тус бүрдээ гурван шугамтай найман хүлэл нь дотроо үржин олшроод 64 болж, ингэснээр аливаа хувьсал өөрчлөлт, нөхцөл байдал, боломж зэргийг төлөөлөх утгатай болно. Ийнхүү энэ үзлээр, цогц соёл иргэншлийг системтэй, дэвшин урагшлах үйл явц гэж ойлгож болно.

Энэ сургаалын хувьд өөрчлөлт хувирлын тогтолцоо нь Тэнгэр Газар гэсэнтэй утга нэг болох тул Тэнгэр Газарт хандаж нийцэн тохирч байдаг юм. Өөдөө бид хараад тэнгэрийн одод мичдийг ширтэнэ, уруугаа буюу доошоо харахдаа газар дээрх дэг журам нягтлан үзнэ. Учир тиймийн тул бид далд нууц ч, зүйл мөн түүнчлэн илт зүйлийн ч учир шалтгааныг танин мэднэ. Аливаа юмс үзэгдлийн орчлыг бид нягтлан үзэхүй амьдрал үхлийн тухай ойлголт ухагдахууныг ухаарна.

“Инь-яны сургаал”- аар: “Мөн чанар хийгээд материаллаг хүч буюу ch'i хоёр нь зохироод юмс /үзэгдэл/ хэвийн орших болно. Сэтгэл сүнс буюу хүч нь холдохоор өөрчлөлт тэр болно. Үүнээс бид оюуны оршихуйн нөхцөл шинж байдал зэрэг нь Тэнгэр Газрынхтай ижил төстэй ба тэдний хооронд зөрчил гэж үгүй. Сэтгэл сүнсийг мэдэх аваас аливаа зүйлийг мэдэх болж түүний арга зам нь тэнгэрийн доорх бүхий л зүйлд тус дэм болж ингэх аваас аливаа алдаа эндүүрлээс сэргийлж чадна. Энэ нь чөлөөтэй байх ба замаа үл алдана. Байгаль дэлхийд баясан хувь тавиланг танин ойлгоно. Тиймийн тул сэтгэл зовох зүйлгүй болно. Аливаа зүйлс байх газраа байж сайн үйлсийг бүтээх аваас хайр тэнд үүснэ”¹².

¹² A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P.265

Өөрчлөлт нь бүхний үндэс блох талаар энэхүү сургаалд өгүүлэхдээ: “Арга билгийн бүтээлч үр дүн бүхий хөдөлгөөн нь арга замыг /Тао/ нь тодорхойлох бөлгөө. Энэхүү арга замаас аль сайн нь хүний ажил үйлст хэрэгжин биелнэ. Хүмүүнлэг хүн үүнийг нь танин мэдэж хүнлэг чанар хэмээмүй, ухаант мэргэн нэгэн нь үүнийг мэргэн ухаан хэмээх. Харин хүмүүс нийтдээ хавтгайдаа үүнийг эс ухааран үл мэдэн байх. Сайхан сэтгэл сүнс нь хүний хүмүүнлэг сайхан явдалд илэрч хэрэгжих үйлдэлд нуугдан байх ба энэ сэтгэл сүнс нь агуу их буянт үйлсдээ ч, их амжилтдаа ч яасан их төгс билээ ! Ололт амжилт нь аливааг эзэмдэх тул агуу билээ, аливааг ямагт өөрчлөн хувиргаж шинэчлэх тул цаглашгүй арвин билээ”¹³ гэжээ. Юмс үзэгдэл цаг үргэлж өөрчлөгдөн хувирдаг тухай энэхүү үзэл санаа нь хятадын философид хүчтэй уламжлагдан нөлөөлсөн түүхтэй билээ.

Өөрчлөгдөн хувирна гэдэг нь шинээр бүтэх буй болох, нөхөн сэргэх гэсэн утгатай юм. Өөрчлөлт нь бодол санаа ч биш, үйл явдал ч биш, энэ нь үнэмлэхүй амар амгалан хийгээд эс хөдлөх үйлдэх байдалд оршино. Харин үйл хөдөлгөөнд орох аваас аливаад нэвтрэн орно. Энэ хорвоо ертөнцөд сүнс сүлд хэмээх зүйл байгаагүйсэн бол өөрчлөлт хувиралтад оролцохгүй байж яахин чадах билээ? Тиймээс өөрчлөлт хувирлын тогтолцоо нь мэргэн ухаан юмсын хязгаарт хүрч тэдгээрийн тун ч нарийн илрэл үзэгдлийг нягтлан таниж байхыг хэлэх ажээ. Гүн гүнзгийд нэвтрэх чадаж баймаажин тэр олон хүмүүний хүсэл эрмэлзэлд нэвтрэн хүрч чадна. Чухамхүү тэр нарийн нандин үйл хөдлөлөөр л энэ хорвоогийн аливаа явдал зам мөр нь биеллээ олж чухамхүү сэтгэл сүнсний ачаар л эс яарсан атлаа амжуулж гүйцэлдүүлэх, эс аялсан хэрнээ хүрч очсон байх ажээ...

Түүнчлэн K'un (газар) нь хаахын нэр, Ch'ien (тэнгэр) нь нээхийн нэр болой. Хаах нээхийн дараалал нь өөрчлөлт хувирлыг буй болгоно. Ирэх одох буюу арга билиг ээлжлэн дараалах нь нэвтрэхүй болой. Ил илт буй зүйл нь hsiang буюу хэлбэр мөн болой. Бодит биеийг олсон /материаллаг/ зүйлийг ch'i буюу бодит зүйл хэмээнэ. Аливаа зүйлийг хянаж ашиглахыг арга хэмээнэ. Хэрэв тэдгээрийг ашиглаж аль нэг арга замаар ач тусыг /давуу тал/ хүртэх аваас хүн бүхэнд хүртээлтэй ашигтай тустай зүйл болно. Үүнийг л сэтгэл сүнс гээд байгаа юм.

Энэхүү зохиолд бичсэнээр: “Нар мандахад сар жаргана. Сар мандахад нар жаргана. Ийнхүү нар сар хоёр бие биенээ шахаж ээлжлэхэд гэрэл гэгээ буй болно. Өвөл шувтарч зун болно. Ийнхүү өвөл зун хоёр ээлжлэхэд жил болно. Явахуй дор агшина, ирэхүй дор тэлнэ. Агших тэлэхэд ашиг тус гарна. Өт агшихдаа тэлэж сунах гэсэндээ тэр. Луу хийгээд могой ичихдээ амьд гарах гэсэндээ тэр. Юмс үзэгдлийн үндсийг мөрдөн мөшгиж танихдаа мөн чанарт нь нэвтрэх нь чухал, ингэж чадах аваас бид тэдгээрийг хэрэглэж ашиглаж ач тусыг нь хүртэн дотоод амар амгаланг амтлан байх билээ. Юмсын чанадад болж буй зүйлийг мэдэж авах нь бидний чухаг хэрэг билээ.

¹³ A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P. 267

Сэтгэл сүнсийн чанад гарч буюу хязгаарт тултал таниж мэдээд хувьсал өөрчлөлтийг таньж авах аваас тэмүүлэн хүрэх өндөрлөг тэр бөлгөө”¹⁴.

Бас өөрчлөлт хувирлын тогтолцоонд Их төгсгөл байдаг ажээ. Энэ нь хоёр их арга буюу арга билгийг бүтээн буй болгоно. Энэ хоёр нь улмаар дөрвөн хэлбэрийг буюу их бага арга билигийг бүтээн буй болгодог. Найман хүлэл нь сайн муу заяаг тодорхойлно. Сайн муу заяа нь энэ насны их үйлс явдал мөрийг тодорхойлно.... Ийнхүү өөрчлөлт хувирлын тогтолцоо нь үнэн хэрэгтээ арга билгийн үйлдэлд хослон байх ажгуу. Арга билиг хоёр нь зохих байр сууриа олмогц Өөрчлөлт хувирлын тогтолцоо нь ч төвийн байр сууриа оллоо гэсэн үг юм. Арга билиг хоёр арчигдан уствал өөрчлөлт хувирлын тогтолцоо ч учир утгагүй болно гэсэн үг билээ. Өөрчлөлт хувирлын тогтолцоо эс үзэгдэх аваас арга билгийн үйл явц ч тасалдаж үйлчлэхээ болино.

Эцэст нь дүгнэн хэлэхэд, энэхүү “инь, яны” философи нь ертөнцийн юмс үзэгдлийн өөрчлөлтийн үйл явцыг тайлбарлахын зэрэгцээ хамгийн чухал нь ертөнцийн үзэгдэл үйл явцын ялгаа, олон янз байдлын дотоод нэгдэл, тэдгээрийн язгуур чанарыг олж ухаарах арга зүй юм. Энэ нь нэг талын үзлээс ангид байх, аливаа судлагдахууны дотоод мөн чанарт гүнзгий нэвтэрнэ гэсэн үг. Гэвч энэ дотоод нэгдлийг танин мэдэх нь тийм ч хялбар бус, учир нь тэр чанар нь өөрөө хөдлөмтгий, хувьсамтгай, харьцангуй юм. Нийгэм-улс төр, хувь хүний амьдрал, танин мэдэхүйд аль нэг үзлийг ганц үнэн хэмээн туйлшрах нь алдаанд хүргэдэг болохыг анхааруулж буй үзэл, арга зүй юм. Иймд “инь, яны” философийн арга зүй нь зөрчилт олон талын дотоод нэгдлийг эрхэмлэх, түүнд хүрэхийг зорилт болгодог онол, арга зүй билээ.

“Инь, яны” философийн арга зүй бол эсрэг тэсрэг харилцааг хэрхэн ухаарч, шийпвэрлэх арга зүй юм. Эсрэг тэсрэг тал нь дотоод чанараас үндэстэй ч голдуу өнгөн талдаа илэрч байдаг болно. Иймд бид тэр зөрчил сөргөлдөөнд сааталгүйгээр үзэгдэл үйл явцын дотоод нэгдлийг танин мэдэж чадсанаар ертөнцийн нэгдмэл чанарыг ойлгох боломжтой болно. Хэрвээ нийгэм болон хүнээ зөв танин мэдэж, хөгжүүлье гэвэл зөрчил тэмцлийг гол болгон тэмцэлдүүлж, нураах бус, харин тэр нэгдмэл чанарыг танин ухаарч, үйл ажиллагаандаа баримтлах нь эв нэгдлийн үндэс суурь болох юм. Тэгэхлээр “инь, яны” философи нь нэгдлийн философи юм.

SUMMARY

The Yin Yang doctrine is very simple but its influence has been extensive. No aspect of Chinese civilization - whether metaphysics, medicine, government, or art - has escaped its imprint. In simple terms, the doctrine teaches that all things and events are products of two elements, forces or principles: yin, which is negative, passive, weak, and destructive, and yang, which is positive, active, strong, and constructive.

¹⁴ A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973. P. 268

In Chinese philosophy, the concept of yin yang is normally referred to in the West as "yin and yang" and is used to describe how polar opposites or seemingly contrary forces are interconnected and interdependent in the natural world, and how they give rise to each other in turn. Opposites thus only exist in relation to each other. The concept lies at the origins of many branches of classical Chinese science and philosophy. Many natural dualities - e.g. dark and light, female and male, low and high, cold and hot - are thought of as manifestations of yin and yang (respectively). Yin yang are complementary opposites that interact within a greater whole, as part of a dynamic system. Everything has both yin and yang aspects, but either of these aspects may manifest more strongly in particular objects, and may ebb or flow over time.

НОМ ЗҮЙ

- A source book in Chinese Philosophy. USA. Princeton, New Jersey. 1973
- Р.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006
- Oxford dictionary of philosophy. Shanghai. 2000
- Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003